

АГУУЛГА

Байгууллагын товч танилцуулга, бүтэц

Эрхэм зорилго

ББСБ-ын салбарын судалгаа

Зээлийн үйл ажиллагаа

Санхүүгийн үзүүлэлт

БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Прогресскапитал ББСБ нь 2010 оны 03 сарын 15 -ны өдөр шинээр байгуулагдсан. Ш.Баттогтох, Ч.Тунгалаг, Т.Туул гурван хувьцаа эзэмшигчтэйгээр 100% хувийн өмчид тулгуурлан үйл ажиллагаагаа явуулж эхлэсэн.

- 2010 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 192 дугаар тогтоолоор зээлийн үйл ажиллагаа эрхлэх, гадаад валютын арилжаа, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвөлгөө, мэдээлэл өгөх банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрлөө авсан.
- 2013 оны 10 сарын 23-ны өдрийн 378 дугаар тогтоолоор Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн эрх авсан.
- 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 280 дугаар тогтоолоор Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрлийн эрх авсан.
- 2023 оны 01 сарын 13-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвууллагын үйлчилгээ тусгай зөвшөөрөл эрх аван ажиллаж байна.

Байгууллагын бүтэц:



ШИНЭЭР НЭВТРҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ, ПРОГРАММ ХАНГАМЖ

2020 оны 6 сард Сайн Интернэшнл ХХК-тай хамтран Лизингийн зээл олгож харилцагчиддаа илүү ойртон түргэн шуурхай үйлчилгээг үзүүлж эхэлсэн.

2020 оны 8 сард Грэйпсити Монгол ХХК-ийн Поларис систем рүү шилжин ажилчдын үйл ажиллагааг хялбарчлан финтек зээл гаргахад зориулан программ хангамжаа шинэчилэн ажилласан.


2022 оны 12 сард Мост Финтек ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Прогресскапитал ББСБ аппликэшн зээлийг эхний ээлжинд харилцагч нартаа санал болгон ажиллах төлөвлөгөөтэй байгаа.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид харилцагчийн эрх ашгийг дээдэлсэн, бүтээлч чадварлаг боловсон хүчинтэй, нийгмийн хариуцлагатай, нээлттэй, санхүүгийн салбартаа шилдэг байгууллага байна.

Бичил санхүүгийн зах зээлд дээрх байгууллагуудын ирээдүйн бодит боломжийг нээн илрүүлж, шинэ санаа, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг манлайлан дэлгэрүүлдэг, олон улсын стандартад нийцсэн “Үндэсний чадамжтай” байгууллага болох зорилготой.

Зах зээлийн шинжилгээ: Одоогоор Санхүүгийн зохицуулах хорооноос албан ёсоор 522 банк бус санхүүгийн байгууллага тусгай зөвшөөрөл аван үйл ажиллагаа явуулж байна. Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй банк бус санхүүгийн байгууллагын тооны өөрчлөлтийг графикаар үзүүлбэл:




Энэ үзүүлэлтээс харахад Банк бус санхүүгийн байгууллага нь 2014 оноос хойш нэмэгдэж байгаад сүүлийн жилүүдэд тогтвортой байна.

ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Манай нийгэм эдийн засгийн амьдралд үзүүлэх цар тахлын нөлөө хэвээр байсан ч бид жилийн эцэс гэхэд нийт зээлийн багцаа 23.6 тэрбум төгрөгт хүргэж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.79 хувиар өсгөж чадлаа. Нийт олгосон зээлийн 44 хувийг лизингийн зээл, 21.5 хувийг хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл , 26.1 хувийг хэрэглээний зээлийн олголт бүрдүүлсэн байна.

Үзүүлэлт (сая төгрөг)	2021	2022	Өсөлтийн хувь
Олгосон зээлийн тоо	6,833	7,651	11.97%
Олгосон зээлийн дүн	22,512.47	27,519.16	22.24%
Нийт идэвхтэй зээлийн тоо	6644	9878	48.68%
Нийт зээлийн багц	18,652.70	23,649.83	26.79%
Үндсэн зээлийн эргэн төлөлтийн дүн	18,490.07	22,519.82	21.79%
Зээлийн хүү	5,261.13	7,443.51	41.48%


Зээлийн багц, харилцагч тоо /сая.₮/




Чанаргүй зээл / сая.₮/



Эх үүсвэр / сая.₮ /



Нийт хөрөнгө / сая.₮ /



Цэвэр ашиг / сая.₮ /

